



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Дорнод аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2020 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: ДОО-2021/103/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Батжаргал

Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....3-4

2. Аудитын тайлан.....5

2.1. Ерөнхий зүйл.....5

2.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....5

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....6

2.4. Материаллаг байдал.....6

2.5. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....6

2.6. Аудитын илрүүлэлт.....6

2.7. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....6

3. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....7



1.Хараат бус аудиторын дүгнэлт





3.Аудитын тайлан

2.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Гарамхишиг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Батжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төв 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 16 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн ч санхүүгийн тайлангийн аудит хийхэд шаардлагатай цалин, бараа материалын санхүүгийн баримт материалыг Төрийн аудитын газарт ирүүлээгүй.

2.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ус, цаг уур, уур амьсгал, байгаль орчны бодит болон ирээдүйн төлөв байдлын тухай мэдээллээр төр засаг, нийгэм эдийн засаг, хүн амын эрэлт хэрэгцээг хангах,
- Ус, цаг уур, уур амьсгал, байгаль орчин, тандан судалгаа хийх, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж, үнэлгээ гаргах,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ус, цаг уур, орчны шинжилгээний төв санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас дотоод аудит хийгдэж аудитын тайлангийн төслийг 2021 оны 02 сарын 22-ны 47 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна. Дотоод аудитаар цалин хөлс, мал аж ахуй, тээвэр шатахууны зардалтай холбоотой материаллаг хэмжээний зөрчлүүд илэрсэн байна.



2.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 976,844.7 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 19,536.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 1,217,081.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 24,341.6 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

2.5. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 15,927.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, төлбөрийн актыг биелүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн актыг хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	15,059.7	1	15,059.7	-	-	-
Төлбөрийн акт	1	868,2	1	868,2	-	-	-
Нийт дүн	2	15,927.9	2	15,927.9	-	-	-

2.6. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитад шаардлагатай цалин, бараа материалын баримт материалыг Төрийн аудитын газраас шаардсан хуулийн хугацаанд гаргаж өгөөгүй, дотоод аудитаар цалин, мал аж ахуй, тээвэр шатахууны зардалтай холбоотой нийт 69,640.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Дотоод аудитын дүн эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;” 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;”, 16 дугаар зүйлийн 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.” гэсэн заалт /УСНББОУС 1/ тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд аудитын санал дүгнэлт өгөхөөс татгалзаж, сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн.

2.7. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар дотоод хяналт, цалингийн зардал, мал аж ахуй, тээвэр шатахууны зардлын дансыг анхааралдаа авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.



3. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Дорнод аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021			ДОА-2021/103/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорнод аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн аудитын байгууллагаас татгалзсан санал дүгнэлт авсан. Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.”	0	Албан шаардлага	дарга, нягтлан бодогч	Г.Гарамхишиг, Д.Баттуяа
ДҮН		0			

